

БАЯНХОНГОР АЙМАГТ 2022 ОНЫ ЭХНИЙ 8 САРД
БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2022.08.31

Номгон

НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Тус цагдаагийн газар нь 2022 оны эхний 8 сард иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 3656 дуудлага, мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1074 буюу 41.5 хувиар өссөн. Үүнээс 870 буюу 23.8 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 2786 буюу 75.2 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол байна.

Аймгийн хэмжээнд энэ оны 8 сард 341 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 46 нэгжээр буюу 15.5 хувиар өссөн. Гэмт хэрэгт нийт 245 хүн шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 нэгжээр буюу 9.6 хувиар өссөн бөгөөд 22 эмэгтэй хүн холбогдон шалгагдсан нь 8 нэгжээр буюу 26.6 хувиар, 50 хүн урьд ял шийтгэгдсэн нь 18 нэгжээр буюу 26.4 хувиар тус тус буурсан. Гэмт хэргийн илрүүлэлт 29.9 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 26.7 пунктээр буурчээ.

Гэмт хэргийн улмаас 350 иргэн хохирч, үүнээс 129 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 12 нэгжээр буюу 8.5 хувиар буурч, 13 хүн нас барсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 3 нэгжээр буюу 30 хувиар өсөж, 1208.8 сая төгрөгийн хохирол учирснаас 261.8 сая төгрөгийг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 21.6 хувьтай байна.

Гэмт хэргийн гаралт: Баянхонгор сумын “Номгон” 1-р баг, “Эрдэнэмандал” 2-р баг, “Гэгээг шавь” 6-р баг, “Цахир” 7-р баг, “Шаргалжуут” 8-р баг, “Есөнбулаг” 9-р баг, “Рашаант” 10-р баг, Баянбулаг, Баян-Овоо, Богд, Бууцагаан, Галуут, Жинст, Өлзийт Хүрээмарал, Шинэжинст сумдад тус тус **өсөж**, Баянхонгор сумын “Дуурсах” 3-р баг, “Цагаанчулуут” 5-р баг, Баацагаан, Баянлиг, Баянцагаан, Бөмбөгөр, Гурванбулаг, Жаргалант, Заг, Эрдэнэцогт сумдад буурч, Баянхонгор сумын “Угалз” 4-р баг, Баянговь, Баян-Өндөр сумдад урьд оны мөн үетэй ижил түвшинд байна.

Хэргийн төрлөөр: хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 106 бүртгэгдэж 24.5 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 2 бүртгэгдэж 33.3 хувиар, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 14 бүртгэгдэж 33.3 хувиар тус тус **буурч**, хүчиндэх гэмт хэрэг 15 бүртгэгдэж 50 хувиар, хулгайлах гэмт хэрэг 62 бүртгэгдэж 47.6 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 27 бүртгэгдэж 80 хувиар, залилах гэмт хэрэг 55 бүртгэгдэж 1.8 дахин, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 21 бүртгэгдэж 61.5 хувиар, бусад гэмт хэрэг 33 бүртгэгдэж 7 нэгжээр буюу 26.9 тус тус **өссөн**.

Үйлдэгдсэн байдлаар: Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 85 бүртгэгдэж 33 нэгжээр буюу 27.9 хувиар, эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 26 бүртгэгдэж 1 нэгжээр буюу 3.7 хувиар тус тус буурч, бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 31 бүртгэгдэж 3 нэгжээр буюу 10.7 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 32 бүртгэгдэж 3 нэгжээр буюу 10.3 хувиар, хүүхэд оролцсон хэрэг 26 бүртгэгдэж 15 нэгжээр 1.3 дахин тус тус өссөн.

Үйлдэгдсэн газраар: Баянхонгор аймагт бүртгэгдсэн 341 гэмт хэргээс 104 буюу 30.4 хувь нь гэр орон сууцанд, 43 буюу 12.6 хувь нь гудамж талбайд, 29 буюу 8.5 хувь нь олон нийтийн газар, 21 буюу 6.1 хувь нь авто замд, 4 буюу 1.1 хувь нь төрийн байгууллага, 7 буюу 2 хувь нь аж ахуйн нэгжид, 132 буюу 38.7 хувь нь бусад газарт үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн цаг хугацаагаар нь: 22-06 цагийн хооронд 123 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 36 хувь, 06-14 цагийн хооронд 66 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 19.3 хувь,

14-19 цагийн хооронд 110 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 32.2 хувь, 19-22 цагийн хооронд 42 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 12.3 хувийг эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 54 буюу 15.8 Даваа гарагт, 60 буюу 17.5 хувь нь Мягмар, Лхагва гарагт тус тус, 51 буюу 14.9 хувь нь Пүрэв гарагт, 39 буюу 11.4 хувь нь Баасан гарагт, 38 буюу 11.1 хувь нь Бямба гарагт, 39 буюу 11.4 хувь нь Ням гарагт үйлдэгджээ.

ХОЁР. ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд 2022 оны 08 дугаар сард нийт 13395 зөрчил шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2393 зөрчлөөр буюу 21.7 хувиар өссөн. Бүртгэгдсэн зөрчлийн 13308 буюу 99.3 хувийг шийдвэрлэсэн байна.

Бүртгэгдсэн зөрчлөөс 11450 зөрчлийг ердийн журмаар 295802.8 төгрөгөөр, 1311 зөрчлийг хялбаршуулан шалгах журмаар 388935.0 мянган төгрөгөөр, зөрчлийн хэрэг нээн шалгасан 93 зөрчлийг 21720.0 мянган төгрөгөөр /нийт торгууль 656457.8/ тус тус торгож шийдвэрлэсэн байна.

Энэ хугацаанд 441 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь 114 нэгжээр буюу 34.8 хувиар, 587 зөрчлийг торгож, эрх хассан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 83 нэгжээр буюу 16.4 хувиар тус тус өссөн.

Зөрчлийн үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилд эзлэх хувиар:

- | | |
|----------------------------------|----------------------------------|
| - Даваа гарагт 2175 буюу 16.2%, | - Баасан гарагт 2025 буюу 15.1%, |
| - Мягмар гарагт 2099 буюу 15.6%, | - Бямба гарагт 1530 буюу 11.4%, |
| - Лхагва гарагт 2161 буюу 16.1% | - Ням гарагт 1510 буюу 11.2%, |
| - Пүрэв гарагт 1895 буюу 14.1%, | |
| - 06-12 цагт 3585 буюу 26.7 % | - 19-24 цагт 3237 буюу 24.1%, |
| - 13-18 цагт 6098 буюу 45.5%, | - 01-05 цагт 475 буюу 3.5% |

Үйлдэгдсэн онцлогоор нь:

- | | |
|-----------------------------------|---------------|
| • Согтуугаар үйлдэгдсэн | 1333 буюу 10% |
| • Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | 183 буюу 1.3% |
| • Эмэгтэй хүн оролцсон | 283 буюу 2.1% |
| • Хүүхэд оролцсон | 18 буюу 0.1% |

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчил гарган 518 иргэн эрүүлжүүлэгдсэн. Үүний 31 буюу 5.9% нь эмэгтэй эзэлж байна.

нийгмийн байдлаар нь:

- | | |
|-----------------------------|-------------------------------|
| • Ажилгүй | 530 буюу 28.52% |
| • Төрийн албан хаагч | 151 буюу 8.1% |
| • Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 366 буюу 19.7% |
| • Ажилчин, малчин | 545 буюу 29.3% |
| • Бусад | 263 буюу 14.1%-г эзэлж байна. |

Эрүүлжүүлэгдсэн шалтгаанаар нь:

- | | |
|---|----------------|
| • Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан | 434 буюу 83.7% |
| • Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон | 2 буюу 0.3% |
| • Тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон | 14 буюу 2.7% |
| • Хаана байгаага, очих газраа мэдэхгүй болсон | 9 буюу 1.7 % |
| • Гэмт хэрэг, зөрчилд өртөж болзошгүй | 23 буюу 4.4% |
| • Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | 8 буюу 1.5% |
| • Гудамж талбай, олон нийтийн газар ухаангүй байсан | 28 буюу 5.4% |

Эрүүлжүүлэгдсэн газраар нь:

- | | |
|----------------------|----------------|
| • Гэр, орон сууцнаас | 402 буюу 77.6% |
| • Гудамж талбайгаас | 79 буюу 15.2% |

- Байгууллага, аж ахуйн нэгжээс 16 буюу 3%
- Үзвэр, үйлчилгээний газраас 1 буюу 0.1%
- Баар, цэнгээний газраас 8 буюу 1.5%
- Зочид буудлаас 5 буюу 0.9%
- Бусад 7 буюу 1.3 % нь эрүүлжүүлэгджээ

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 27.9 хувиар буурсан хэдий ч бүртгэгдсэн гэмт хэргийн 24.9 хувь нь, зөрчлийн 10 хувийг согтуугаар, гэмт хэргийн 9.3 хувь нь, зөрчлийн 1.3% нь гэр бүл, хүчирхийллийн улмаас үйлдэгджээ.

Мөн хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 24.5 хувиар буурсан хэдий ч бүртгэгдсэн хэргийн 106 буюу 31 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 164 буюу 48 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг эзэлж байгаа бөгөөд эдгээр 2 бүлгийн гэмт хэрэг нь нийт хэргийн 79 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа үзүүлэлт юм.

Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 212 буюу 62.1 хувь нь Баянхонгор суманд үйлдэгдэж 52 хувиар өсөж, 129 буюу 37.8 хувь нь бусад сумдад үйлдэгдэж 4.4 хувиар буурчээ.

Мал хулгайлах гэмт хэрэг 80 хувиар, залилах гэмт хэрэг 1.8 дахин өссөн. Тэр дундаа залилах гэмт хэрэг нь цахим орчинд үйлдэгдэх тохиолдол өссөөр байгаа нь анхаарал татаж байна.

Гэмт хэргийн илрүүлэлт аймгийн хэмжээнд 29.9 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.7 хувиар буурсан нь цаашид гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг тасралтгүй авч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

Гэмт хэрэг, зөрчилд холбогдогчдын нийгмийн байдлаар нь авч үзэхэд гэмт хэрэгт холбогдсон иргэдийн 115 буюу 46.9 хувь нь ажилгүй, 52 буюу 21.2 хувь нь малчин, 20 буюу 20.4 хувь нь урьд нь ял шийтгэгдсэн иргэн бол, гэмт хэрэгт өртөж хохирогчдын 91 буюу 26 хувь нь ажилгүй, 88 буюу 25.1 хувь нь малчин иргэд байна. Зөрчилд холбогдогчийн 545 буюу 29.35 хувь хувь нь тус тус малчин иргэд байгаа нь тэдний хууль, эрх зүйн мэдлэг, мэдээлэл дутмаг байгаатай холбоотой гэж дүгнэж байна.

Энэ хугацаанд 26 хэрэгт 50 хүүхэд холбогдон шалгагдсан нь насанд хүрээгүй хүнээс гэмт хэрэг бүлэглэн үйлдэх явдал өссөн байна.

ДӨРӨВ: ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

алилах болон цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд иргэдэд чиглэсэн мэдээлэл, сургалтууд, нөлөөллийн ажил арга хэмжээг тасралтгүй зохион байгуулах, олон нийтэд түгээх,

рөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийн талаарх, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах,

ургуулийн орчинд үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлж “Сургуулийн цагдаа” эргүүлийг тогтмол идэвхтэй ажиллуулах.
агдаагийн газраас гэмт хэргийн гаралт өсөлттэй байгаа сум, багийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд “Зөвлөмж” хүргүүлэх,

Та бүхний ажилд амжилт хүсье.

ТАНИЛЦУУЛГА ГАРГАСАН:
МЭДЭЭЛЭЛ СУДАЛГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ Б.БЯМБАА

ТАНИЛЦСАН:
ДАРГА,
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА З.БАЯНЖАРГАЛ